

## **2019 ОНЫ 10 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

2019 оны 10 дугаар сард эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийн мэдээг 7 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, НЭМГ/ ирүүлсэн. ГССҮТ, УАУХТ эмнэлгүүдээс мэдээ ирээгүй.

### **Нэг. Амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:**

2019 оны 10 дугаар сард 739 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, амбулаторийн хүлээгдлийн 896 тохиолдол бүртгэгдсэн байна. Тухайлбал:

УНТЭ 164 хүлээгдэл, УХТЭ 260 хүлээгдэл, УГТЭ 104 хүлээгдэл, ХСҮТ 364 хүлээгдэл тус тус бүртгэгдсэн байна. Харин СЭМҮТ, ЭХЭМҮТ амбулаторийн хүлээгдэлгүй ажиллажээ.

Амбулаторийн хүлээгдлийг ЭМБ-аар авч үзэхэд:

УНТЭ-ийн амбулаторийн найман кабинетэд 164 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сар буюу 9-р сараас долоон кабинетэд 111 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэнээс 53 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн харагдаж байна. Үүнд: Зүрх судасны кабинет 1, мэдрэлийн кабинет 32, нүдний кабинет 23, чих хамар хоолойн кабинет 20, урологийн кабинетэд 34, хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 32, хэрх үе судлал 2 хүлээгдэл 2-6 хоногийн хугацаатай хүлээсэн байна.

УХТЭ-т нийт 10 кабинетэд 260 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Энэ нь өмнөх сарын хүлээгдлээс 126 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Бөөр судлалын кабинет 22, зүрх судасны кабинет 9, мэс заслын кабинет 3, мэдрэл судлалын кабинет 5, нүдний кабинет 41, нүдний даралтын кабинет 41, чих хамар хоолойн кабинет 43, булчирхай судлалын кабинет 13, хоол боловсруулах эрхтэн судлалын кабинет 49, эмэгтэйчүүдийн кабинет 33 үйлчлүүлэгч тус тус 2-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 13 кабинетэд 241 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.


УГТЭ-ийн 3 кабинетэд нийт 104 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 110 хүлээгдлээр буурсан харагдаж байна. Хоол боловсруулах эрхтэн системийн кабинет, чих хамар хоолойн кабинет, цээжний хөндийн мэс заслын кабинет, элэг цөс нойр булчирхайн кабинет, зүрхний мэс заслын кабинетүүдийн хүлээгдэл буурсан буюу хүлээгдэлгүй байна.

Үүнд: Зүрх судасны кабинетэд 46, мэдрэлийн кабинет 26, хоол боловсруулах эрхтэн системийн кабинет 32 үйлчлүүлэгч 1-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 15 кабинетэд 410 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


ХСҮТ-ийн амбулаторид 88 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч 11 кабинетэд нийт 364 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын

хүлээгдлээс 176 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн харагдаж байна. Үүнд: Зүрх судасны кабинет 32, мэс заслын кабинет 3, цээжний хөндийн мэс засал 49, элэг цөс нойр булчирхайн кабинет 54, толгой хүзүүний мэс заслын кабинет 34, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинет 68, гепатологийн кабинет 21, туяа эмчилгээний кабинет 29, хими эмчилгээний кабинет 45, хөнгөвчлөх 1, ангиографийн кабинет 28 үйлчлүүлэгч тус бүр 2-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 88 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УНТЭ, УГТЭ-ийн 2019 оны 10-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



ХСҮТ-ийн 10-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



### Хоёр. Оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2019 оны 10 дугаар сард 465 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн ба УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад 685 хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 160 хүлээгдлээр нэмэгдсэн харагдаж байна.

Оношилгооны хүлээгдлийн ЭМБ-аар авч үзвэл:


УНТЭ-ийн рентген, хэвлийн ЭХО, тархины цахилгаан бичлэг, доплерографи, захын судасны ЭХО, бүдүүн шулуун гэдэсний дуран, урологийн оношилгооны дурангийн кабинетуудаар оношлуулахаар 241 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн 162 үйлчлүүлэгч, 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн 79 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 150 үйлчлүүлэгчийн хүлээгдлээр нэмэгдсэн байна. Үүнд:

Рентген зураг 52, хэвлийн эхо 85, тархины цахилгаан бичлэг 9, доплерографи 29, захын судасны ЭХО 12, бүдүүн гэдэсний дуран 38, урологийн оношилгооны дуран 16 үйлчлүүлэгч оношлуулахаар 2-14 түүнээс дээш хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.




УХТЭ-т 173 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, рентген зураг, зүрхний цахилгаан бичлэг, нүдний уг харуулах, хэвлийн ЭХО харах, ходооны дуран, холтер, доплерийн шинжилгээнд оношлуулахаар 160 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд:

Рентген зураг 58, зүрхний цахилгаан бичлэг 13, хэвлийн эхо 58, ходоодны дуран 12, холтер 2, доплерографи 16, нүдний уг 1, үйлчлүүлэгч оношлуулахаар 2-6 хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.




УГТЭ-т 101 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, рентген зураг, зүрхний цахилгаан бичлэг, хэвлийн ЭХО харах шинжилгээнүүдэд оношлуулахаар 83 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Рентген зураг 25, зүрхний цахилгаан бичлэг 25, хэвлийн эхо 33 үйлчлүүлэгч тус бүр 2-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.



ХСҮТ-д анх удаа оношлуулахаар дугаар авсан 278 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 74 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 150 үйлчлүүлэгч, 2-6 хоногийн хүлээгдэлтэй 49 үйлчлүүлэгч байна. Үүнд:

Ходоодны дуран 25, хэвлийн ЭХО 88, зүрхний цахилгаан бичлэг 29, бүдүүн шулуун гэдэсний дуран 1, рентген харалт 56 үйлчлүүлэгч тус бүр 2-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 133 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 118 өдөртөө, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 4 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна. 2-6 хоногийн хүлээгдэлтэй 4 үйлчлүүлэгч байна.

ЭХЭМҮТ-д оношилгооны хүлээгдэлгүй ажилласан байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны кабинетийн 9, 10-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:

Оношилгооны хүлээгдэл	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар
	УНТЭ		УХТЭ		УГТЭ		ХСҮТ		СЭМҮТ		Нийт	
Рентген зураг		52	38	58	20	25					58	135
Рентген харалт							47	56			47	56
Зүрхний цахилгаан бичлэг			6	13	25	25	33	29			64	67
Нүдний уг харах				1							0	1
Хэвлийн ЭХО	19	85	42	58	35	33	91	88			187	264
Ходоодны дуран			18	12			24	25			42	37
Холтер				2							0	2
Урологийн оношилгооны дуран	14	16									14	16
Эмгэг сэтгэл судлал									39	4	39	4
Тархины цахилгаан бичлэг	4	9									4	9
Бүдүүн гэдэсний дуран	27	38					3	1			30	39
Захын судасны ЭХО		12									0	12
Допплерографи	22	29	13	16							35	45
MRI	1	0									1	0
КТГ	4	0									4	0
<b>Нийт</b>	<b>91</b>	<b>241</b>	<b>117</b>	<b>160</b>	<b>80</b>	<b>83</b>	<b>198</b>	<b>199</b>	<b>39</b>	<b>4</b>	<b>525</b>	<b>687</b>

Оношилгооны хүлээгдлийг хоногоор нь харьцуулбал:

Үзүүлэлт	2019 оны 9, 10 сарын оношилгооны хүлээгдэл хоногоор:											
	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар	9 сар	10 сар
	УНТЭ		УХТЭ		УГТЭ		ХСҮТ		СЭМҮТ		Нийт	
Өдөртөө	0	52	173	158	100	101	76	51	130	118	479	480
1 хоног	6	3	72	56	72	67	15	5	8	11	173	142
2 хоног	24	0	38	140	60	58	66	5	7	0	195	203
3-6 хоног	18	162	79	20	20	25	7	44	32	4	156	255
7-14хоног	22	79	0	0	0	0	68	55	0	0	90	134
15ба түүнээс дээш	27	0	0	0	0	0	57	95	0	0	84	95
<b>Бүгд</b>	<b>91</b>	<b>241</b>	<b>117</b>	<b>160</b>	<b>80</b>	<b>83</b>	<b>198</b>	<b>199</b>	<b>39</b>	<b>4</b>	<b>525</b>	<b>687</b>

## Гурав. Лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2019 оны 10 дугаар сард УНТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ эмнэлгүүд лабораторийн шинжилгээний хүлээгдэлгүй ажилласан байна.

УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэгдсэнийг дүгнэхэд: 725 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлсэн ба лабораторид шинжилгээ өгөхөөр 297 хүлээж үйлчлүүлсэн байна. Өмнөх сарын хүлээгдлээс 12 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна.

УХТЭ-т 434 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, 107 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Үүнд:

Цусны ерөнхий шинжилгээ 9, шээсний ерөнхий шинжилгээ 5, биохими 60, бактериологийн шинжилгээ 24, иммунологийн шинжилгээ 4, сериологийн шинжилгээ 1, коагулограммын шинжилгээ 4 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.


УГТЭ-т 291 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн боловч, 190 үйлчлүүлэгч 2-6 хоногийн хүлээгдэлтэй үйлчлүүлж өмнөх сарын хүлээгдлээс 85 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

Цусны ерөнхий шинжилгээ 67, биохимийн шинжилгээ 98, иммунологи 25 үйлчлүүлэгч 2-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Шээсний ерөнхий шинжилгээ, бактериологи, серологи, цитологи, иммунологи коагулограммын шинжилгээнүүд хүлээгдэлгүй байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 2019 оны 10-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:





### Дөрөв. Хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2019 оны 10 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ ЭХЭМҮТ, НЭМГ-ын харьяа ЭМБ-ууд бүртгэн мэдээлснийг дүгнэхэд:

ЭХЭМҮТ, УНТЭ-ийн хэвтүүлэн эмчлэх тасагуудад хүлээгдэлгүй ажилласан байна.

УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ий хэвтэн эмчлэх тасгуудад 3-6 хоногийн хүлээгдэлтэй 187 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 169 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 50 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 116 үйлчлүүлэгч нийт 522 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн байна.

Хэвтэн эмчлэх тасгийн хүлээгдлийг хоногоор авч үзвэл:

Хүлээгдэл /хоногоор/	УНТЭ	УХТЭ	УГТЭ	ХСҮТ	ЭХЭМҮТ	СЭМҮТ	ГССҮТ	УАУХТ	Нийт
1-3 хоног	0	41	29	67	0	5	0	0	142
3-6 хоног	0	65	38	69	0	15	0	0	187
7-14 хоног	0	42	19	94	0	14	0	0	169
15-30 хоног	0	1	13	36	0	0	0	0	50
1-сараас дээш	0	0	106	10	0	0	0	0	116
3 хоногоос дээш хоногийн хүлээгдэл		108	176	209	0	29	0	0	522

УХТЭ-т 10-р сард 3-6 хоногийн хүлээгдэлтэй 65, 7-14 хохнгийн хүлээгдэлтэй 42 15-30 хоногийн хүлээгдэлтэй 1 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд:

Бөөрний тасагт 3, зүрх судасны системийн тасаг 7, уушигны тасаг 1, мэс заслын тасагт 46, мэдрэлийн тасагт 14, уламжлалт эмчилгээний тасагт 25, хоол боловсруулах эрхтэн системийн тасагт 12 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т 10-р сард 38 үйлчлүүлэгч 3-6 хоног, 19 үйлчлүүлэгч 7-14 хоног, 13 үйлчлүүлэгч 15-30 хоног, 106 үйлчлүүлэгч 1 сараас дээш хоног хүлээж хэвтэн эмчлүүлсэн байна. Үүнд:

Бөөр судлалын тасаг 10, зүрх судасны тасагт 8, чих хамар хоолойн тасагт 70, мэдрэлийн мэс засалд 68, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 11, зүрхний

мэс засалд 5, мэдрэлийн тасаг 4 үйлчлүүлэгч хүлээж үйлчлүүсэн байна. Эндээс харахад чих хамар хоолойн тасаг, мэдрэлийн мэс заслын тасгууд хамгийн олон хоногийн хүлээгдэлтэй ажилласан байна.

ХСҮТ-д 10-р сард 3-6 хоногийн хүлээгдэлтэй 69 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 94 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 36 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 10 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд:

Мэс заслын тасаг 7, элэг цөс нойр булчирхайн тасаг 40, хөнгөвчлөх эмчилгээ 21, хими эмчилгээ 76, толгой хүзүүний мэс засал 3, ангиограф 62 үйлчлүүлэгч 30 хүртэл хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг ба үүнээс хэвтэх шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.


Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

СЭМҮТ-ийн 10-р сард стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 23 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна.

Үүнд: 15 үйлчлүүлэгч 3-6 хоног, 14 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн неврозын тасгийн хүлээгдэл (2019 оны 1-10 сар):





**Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:**

**Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2019 оны 10 дугаар сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ**


№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	10 сар										Наркологийн
			СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	54	5	0	0	5	41	0	3	0	0	0
		1-3 хоног	10	5				2		3			
		3-6 хоног	19				3	7					
		7-14хоног	25				2	32					
		15-30 хоног											
		1 сараас дээш											
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	131	44	40	52	0	35	211	15	0	0	0
		1-3 хоног		14	31	17		2	24	5			
		3-6 хоног	21	10	6	16		5	44	10			
		7-14хоног	49	15	3	19		28	38				
		15-30 хоног	61	5					55				
		1 сараас дээш							50				
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	78	0	0	0	0	74	0	0	0	0	0
		1-3 хоног	12					20					
		3-6 хоног	27					24					
		7-14хоног	39					25					
		15-30 хоног						5					
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	5	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног				3							
		3-6 хоног				2							
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
6	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	100
		1-3 хоног											44
		3-6 хоног											39
		7-14хоног											15
		15-30 хоног											2
		1 сараас дээш											

НЭМГ-ын харъяа 11 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн мэдрэл 54, дотор 131, БГДЭМТ-ийн мэдрэл 41, БЗДНЭ-ийн дотор 211, СХД-ийн ахмадын эмнэлэг 78, БГД-ийн ахмадын эмнэлэг 74, үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 10-р сард 24337 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх сарын дуудлагаас 1120 дуудлагаар буурсан байна. Нийт дуудлагын 32.2%-ийг 0-20 минутад, 33.3%-ийг 21-40 минутад, 20.4%-ийг 41-60 минутад, 11.1%-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Түргэн тусламжийн төвийн 10 дугаар сарын тусламж үйлчилгээний хүлээгдлийг өмнөх сартай харьцуулахад 1 цагаас дээш хугацаанд очсон дуудлага 2.9%-иар буурсан, хамгийн бага хугацаанд (0-20 минут) хүрч үйлчилсэн тохиолдол 2.5%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2019 оны сүүлийн 6 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

### МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА